



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 51 02, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddic.gov.mn,
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2025.04.02 № 01/723
танай _____-ны № _____-т

Журам бүртгүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаартай тушаалаар “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ыг боловсруулж батлууллаа.

Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Дараах баримт бичгийг хавсаргаж хүргүүлэв.

1. Танилцуулга;

2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаартай тушаалаар батлагдсан “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”;

3. Нөлөөллийн шинжилгээний танилцуулга, нөлөөллийн шинжилгээ;

4. Саналын товьёг.



1525060817

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/53 / ... / А/46

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

ЦАХИМ ХӨГЖИЛ,
ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Ц.БААТАРХҮҮ

АТА12939 6806252 9024070591

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД


О.АЛТАНГЭРЭЛ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
нарын 2025 оны 03- сарын 28-ны өдрийн
1/53 /...../ А/76 дугаар хамтарсан тушаалын
хавсралт



ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙГ ХОРИОТОЙ БОЛОН ХҮҮХДЭД ХОРТОЙ АГУУЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Хүүхэд хамгааллын тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 4.1.15, 4.1.16-д заасан хүүхдийг хориотой¹ болон хүүхдэд хортой² агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Энэ журмаар зохицуулах харилцаанд Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлж гаргасан холбогдох журмын зохицуулалтыг баримтална.

Хоёр. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

2.1.Цахим орчинд контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа байршуулахад энэхүү журмын 2.2-т заасан шаардлага болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.12-т заасан орон тооны бус Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-өөс баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу насны ангиллын тэмдэглэгээ байршуулсан байна.

2.2.Цахим орчинд контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа байршуулах этгээд нь дараах шаардлагыг хангасан эсэхийг нягтлах үүрэгтэй:

2.2.1. хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон агуулга орсон эсэх;

2.2.2. хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхэд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл авсан эсэх;

2.2.3. хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүүхдийн эсрэг гэмт хэргийн үйлдэл болон гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан харуулсан, эсхүл сурталчилсан эсэх;

2.2.4.Зар сурталчилгааны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хориглосон агуулгыг түгээсэн эсэх;

2.2.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13.1.2-т заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис,

¹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15."хориотой агуулга" гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

² Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.16."хүүхдэд хортой агуулга" гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг.

тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан, бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг харуулсан эсэх;

2.2.6. Тамхины хяналтын суурь конвенц, Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх, утаат болон электрон тамхи, шинэ төрлийн тамхины бүтээгдэхүүнийг (өсвөр үеийнхний шүтэн биширч, даган дуурайдаг хүмүүсээр хэрэглүүлэх маягаар) далд хэлбэрээр сурталчлах, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэх аргачлал заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан, бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг харуулсан эсэх.

2.3. Цахим орчны үйлчилгээ эрхлэгч³ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.5-д заасны дагуу энэхүү журмын 2.2-т заасныг зөрчсөн контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг түгээхийг хориглоно.

2.4. Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас хамгаалж, урьдчилан сэргийлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.1. цахим орчинд хүүхэд хамгааллын талаар өөрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдах, мэргэшсэн этгээдээс зөвлөгөө, туслалцаа авах;

2.4.2. хүүхдийн ашиглаж буй ухаалаг төхөөрөмжийн эцэг эхийн хяналтын горимыг идэвхжүүлэх, хүүхдийн насны онцлогт тохирсон хязгаарлалт тогтоох;

2.4.3. хүүхдийнхээ ашиглаж буй үүрэн холбооны дугаарыг хүүхдийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/-ийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт үнэн зөвөөр бүртгүүлэн, хэрэглээнд хяналт тавих;

2.4.4. гэр бүлийн орчинд хүүхдийн ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар тохиргоог идэвхжүүлэх;

2.5. Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд боловсролын сургалтын байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.5.1. цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан цахим болон танхимын сургалтыг зохион байгуулах;

2.5.2. сургуулийн болон дотуур байрын орчинд ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар интернэтийн үйлчилгээ эрхлэгч⁴-тэй байгуулах гэрээнд тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.3. багш, ажилтан цахим орчинд нөхөрсөг бус харилцсан суралцагчдын хооронд үүссэн маргааныг зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.5.4. өөрийн үйл ажиллагаанд мөрдөх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой дүрэм, журамд сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, мөрдүүлэх;

2.5.5. багш, ажилтнаас цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулга бүхий мэдээлэл, сурталчилгааг түгээхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

³ Хүүхэд хамгааллын тухай хууль. "цахим орчны үйлчилгээ эрхлэгч" гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

⁴ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.4-т заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийг ойлгоно.

2.5.6.багш, ажилтан боловсролын сургалтын үйл ажиллагаанд хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах, мэдээлэл солилцох, хамтран ажиллахдаа цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангасан платформыг ашиглана.

2.6.Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд интернэтийн үйлчилгээ үзүүлж буй этгээд⁴ дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.6.1.айл өрхөд үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэдтэй эсэхийг тодруулах, хүүхэдтэй тохиолдолд 18+ контентын шүүлтүүртэй байхаар тохиргоог идэвхжүүлэх заавар зөвлөмжөөр хангах;

2.6.2.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.6-д заасан арга хэмжээг авах технологийн боломжийг бүрдүүлсэн байх.

2.7.Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд мөн хуулийн 25.2-т заасан байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.7.1.Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгах, хэрэгжилтийг хангах;

2.7.2.холбогдох олон улсын байгууллага, үндэстэн дамнасан платформ⁵, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, сайн туршлагыг нэвтрүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

2.7.3.цахим орчинд хүүхэд хамгаалахад оролцогч талуудад сургалт зохион байгуулах;

2.7.4.Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

2.8.Хуулийн этгээд нь мөн хуулийн 14.4, 52.7-д заасан сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд сургалтын агуулгад цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлийг тусгах, олон нийт болон өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулна.

Гурав. Хамгаалах үйл ажиллагаа

3.1.Цахим орчинд түгээсэн агуулгаас хориотой болон хүүхдэд хортой агуулгыг мэдээлэх, илрүүлэх, эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь хориотой болон хүүхдэд хортой агуулгаас хамгаалах үйл ажиллагаа (цаашид "хамгаалах үйл ажиллагаа" гэх) болно.

3.2.Хүн, хуулийн этгээд нь цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулга түгээсэн, эсхүл цахим орчин ашиглан хүүхдийг дарамталсан, урхидсан, дээрэлхсэн байж болзошгүй нөхцөл байдлыг Зөвлөл, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн 108 дугаарт мэдээлнэ.

3.3.Энэ журмын 3.2-т заасны дагуу мэдээллийг хүлээн авсан байгууллага нь хүүхдэд хортой агуулга түгээсэн байж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг Зөвлөлд, хориотой агуулга түгээсэн болон цахим орчин ашиглан хүүхдийг дарамталсан, урхидсан, дээрэлхсэн байж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг Хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй шилжүүлнэ.

⁵ Facebook, Instagram, Google, YouTube, TikTok, X гэх мэт

3.4.Хүүхдэд хортой агуулга түгээсэн байж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээлэлтэй холбоотой шийдвэр гаргах харилцааг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.12-т заасан орон тооны бус зөвлөлийн ажиллах журмаар зохицуулна.

3.5.Хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага нь хориотой болон цахим орчин ашиглан хүүхдийг дарамталсан, урхидсан, дээрэлхсэн эсэхийг тогтоож, холбогдогч этгээдэд уг агуулгыг устгах эсвэл түр хязгаарлах талаар хугацаатай мэдэгдлийг хүргүүлнэ. Хориотой агуулга түгээснээс үүсэх хор уршгийг арилгах зорилгоор Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/-оор дамжуулан цахим орчны үйлчилгээ эрхлэгчид агуулгыг устгах эсвэл түр хязгаарлах хүсэлт гаргаж болно.

3.6.Хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага нь энэ журмын 3.5-д заасан мэдэгдлийг мэдээлэл байршуулсан цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл өөрийн цахим сүлжээнд мэдээлсэн цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.

3.7.Зөрчилд холбогдогч этгээд нь энэ журмын 3.5-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг эрх бүхий этгээдэд цахим шуудан, эсхүл утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

3.8. Энэхүү журмын 3.7-д заасан зөрчилд холбогдогч нь энэ журмын 3.4, 3.5-д заасан шийдвэр, дүгнэлтийг эс хүлээн зөвшөөрвөл шийдвэр, дүгнэлт гаргасан байгууллагад гомдлоо, холбогдох тайлбар мэдээллийн хамт гаргах бөгөөд хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

3.9.Зөрчилд холбогдогч этгээд 3.5-д заасан мэдэгдлийн дагуу зөрчлийг арилгаагүй, эсхүл цахим орчны үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй бол хориотой агуулгыг хязгаарлах технологийн арга хэмжээг авах тухай шийдвэрийг хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагаас Зохицуулах хороонд хүргүүлнэ. Шийдвэр нь дараах шаардлагыг хангасан байна:

3.9.1.шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байх;

3.9.2.хэрэгжүүлэх технологийн арга хэмжээ /агуулгыг устгах, хандалтыг хаах, түр хязгаарлах/-ний төрлийг тодорхой тусгасан байх;

3.9.3.зөрчилд холбогдсон цахим хаяг, цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах хугацааг заасан байх;

3.9.4.хориотой агуулга, зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийг байршуулсан цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргах.

3.10.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 3.9-д заасан мэдэгдэлд дурдсан технологийн арга хэмжээг технологийн боломжит хүрээнд нэн даруй хэрэгжүүлэх⁶ бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Зохицуулах хороонд бичгээр, эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ.

⁶ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой контентыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

3.11. Зохицуулах хороо нь энэ журмын 3.5-д заасан эрх бүхий байгууллагаас цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн зөрчил арилсан талаарх шийдвэр, дүгнэлтийг ирүүлсэн тохиолдолд хандалтыг сэргээх технологийн арга хэмжээг нэн даруй авна.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү журмын хүрээнд гомдол, мэдээлэл хүлээн авсан, түүний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгууллага нь хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд хүргүүлж, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

4.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--

ТАНИЛЦУУЛГА

“Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамт өргөн мэдүүлсэн 14 хуулийг хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар зохицуулалтыг хуульчилсан.

Энэхүү журмын зорилго нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад оролцогч талуудын хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан зохицуулна.

Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт “25.11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу төслийг боловсруулан танилцуулж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2020 онд хийсэн “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын үндэсний суурь судалгаа”-ний тайланд Монгол Улсын нийт хүн амын 36.2 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд хүүхдийн мэдээ, мэдээлэл хүлээн авдаг суваг нь фейсбүүк 89%, өргөн нэвтрүүлгийн телевиз 65%, найз нөхөд, үе тэнгийнхнээс 60%-тай гэсэн судалгааны үзүүлэлт гарсан. Түүнчлэн судалгаанд хамрагдсан 13-18 насны хүүхдүүдийн 89% нь цахим орчны дээрэлхэлт, гадуурхалт, халдлагад өртөж байсан дүн гарчээ.

Хүүхдийн тусламжийн 108 утасны төвд 2024 онд цахим дээрэлхэлт дарамттай холбоотой дуудлага 96 ирсэн нь 2023 онтай харьцуулахад 81.3 %- иар буурсан үзүүлэлтэй байна. Мөн цахим орчинд зөвлөгөө хүссэн дуудлага 2024 онд 257 ирсэн нь өмнөх онтой харьцуулахад 42.2%- иар буурсан байгаа нь боловч хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар хууль, эрх зүйн орчны зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

Журмын төслийг Австрали, Солонгос, Тайвань болон Малайз улсын цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчин, зохицуулалтын туршлагыг судалсны дагуу Монгол Улсын хууль тогтоомж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос баталсан “Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах 25 дугаар ерөнхий тайлбар”-тай нийцүүлэн боловсруулсан.

Журмын төсөл нь 4 зүйл, 23 хэсэг, 25 заалттай. Энэхүү журмаар цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хортой болон хориотой агуулгыг түгээснээс үүсэх эрсдэлийг таних, мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулахаар тусгалаа. Мөн уг үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгосноос гадна иргэн, хуулийн этгээдээс

өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нийтэд ил тод мэдээлэхээр журамласан.

Уг журам нь цахим орчинд хүүхдийг хамгаалах үүрэг бүхий талууд болох эцэг эх, асран хамгаалагчид, боловсролын сургалтын байгууллага, цахим орчны үйлчилгээ эрхлэгчид, интернэтийн болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид болон хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг байгууллага мөрдөнө.

Журмын төсөлд санал авах уулзалтыг хүүхэд хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн дагуу үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан 2024 оны 08 дугаар сарын 26, 09 дүгээр сарын 06, 11-ний өдрүүдэд тус тус 3 удаа зохион байгуулж, хэлэлцүүлэгт Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Боловсролын яам, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, Хүүхдийн тусламжийн 108 утасны төв, Дэлхийн зөн монгол олон улсын байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан болон Нийслэл хотын 9 дүүрэг дэх Хүүхдийн эрхийн улсын байцаагчид зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцож нийт 116 саналыг /давхардсан тоогоор/ журмын төсөлд тусгасан болно. Уг журмын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 09 дүгээр сарын 03-наас 10 дугаар сарын 03-ны өдрүүдийн хооронд 30 хоногийн хугацаатай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам тус тус цахим хуудсандаа байршуулж, 15 байгууллагад санал авах албан бичгийг хүргүүлж, нийт 10 байгууллагаас 35 санал ирүүлснээс 33 санал, 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр гаргасан 2 саналыг журмын төсөлд тус тус тусгасан.

“Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу нөлөөллийн шинжилгээг хийсэн.

**“ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙГ ХОРИОТОЙ БОЛОН ХҮҮХДЭД ХОРТОЙ
АГУУЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ ЖУРАМ” БАТЛАХ ТУХАЙ
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД, ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

“Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам” батлах тухай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйл, Хууль зүйн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу нөлөөллийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

1. Захиргааны хэм хэмжээний акт гаргах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана” гэж, Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт “25.11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасан.

Дээрх хуулийн заалтыг тус тус үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар батлах “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төслийг боловсрууллаа.

2. Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах харилцаа

Энэхүү журмаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан. Уг журмыг цахим орчинд хүүхдийг хамгаалах үүрэг бүхий талууд мөрдөнө. Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.1-д эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэр бүлийн орчинд, боловсролын сургалтын байгууллага сургуулийн болон дотуур байрны орчинд, хуулийн этгээд хуульд заасан эрх эдэлж, үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хүүхдэд хортой агуулгаас

хамгаалахаар заасан. Мөн зүйлийн 25.4 хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглосон бөгөөд 25.5-д хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй байхаар тус тус хуульчилсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2020 онд хийсэн “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын үндэсний суурь судалгаа”-ний тайланд Монгол Улсын нийт хүн амын 36.2 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд хүүхдийн мэдээ, мэдээлэл хүлээн авдаг суваг нь фейсбүүк 89%, өргөн нэвтрүүлгийн телевиз 65%, найз нөхөд, үе тэнгийнхнээс 60%-тай гэсэн судалгааны үзүүлэлт гарсан. Түүнчлэн судалгаанд хамрагдсан 13-18 насны хүүхдүүдийн 89% нь цахим орчны дээрэлхэлт, гадуурхалт, халдлагад өртөж байсан дүн гарчээ.

Хүүхдийн тусламжийн 108 утасны төвд 2024 онд цахим дээрэлхэлт дарамттай холбоотой дуудлага 96 ирсэн нь 2023 онтай харьцуулахад 81.3 %-иар буурсан үзүүлэлтэй байна. Мөн цахим орчинд зөвлөгөө хүссэн дуудлага 2024 онд 257 ирсэн нь өмнөх онтой харьцуулахад 42.2%- иар буурсан байгаа нь боловч хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар хууль, эрх зүйн орчны зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-аар цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хортой болон хориотой агуулгыг түгээснээс үүсэх эрсдэлийг таних, мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулахаар тусгалаа. Мөн уг үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгосноос гадна иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нийтэд ил тод мэдээлэхтэй холбогдсон харилцааг нарийвчлан тодорхой зохицуулснаар хуульд нийцүүлэн цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчсөн тохиолдолд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой болно.

3. Захиргааны хэм хэмжээний актын төсөлд

Энэхүү журам нь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт, агуулга байхгүй бөгөөд журам батлагдан хэрэгжсэнээр цахим орчинд хүүхдийг хамгаалах үүрэг бүхий талууд болох эцэг эх, асран хамгаалагчид, боловсролын сургалтын байгууллага, цахим орчны үйлчилгээ эрхлэгчид, интернэтийн болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид болон хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг байгууллага мөрдөнө.

Журмыг одоо ажиллаж байгаа хүний нөөц, техникийн чадавхын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой. Техник эдийн засгийн тооцооллоор зардал, орон тоо шинээр нэмэгдэхгүй ба одоо ашиглаж байгаа хүний нөөц, техник хэрэгсэл, батлагдсан бичиг хэргийн болон бусад зардлын хүрээнд хэрэгжүүлэн ажиллах боломжтой.

4. Захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал авсан байдал.

Энэхүү журмын талаар олон нийтээс 2024 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай санал авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудсанд байршуулсан. Мөн Журмын төсөлд санал авах уулзалтыг хууль тогтоомжоор хүүхэд хамгааллын чиглэлээр үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан 2024 оны 08 дугаар сарын 26, 09 дүгээр сарын 06, 11-ний өдрүүдэд 3 удаа зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт ГБХННХЯ, ХЗДХЯ, ЦХИХХЯ, БЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ, ХГБХХЕГ, ХХЗХ, ХХХҮ-ний түр хамгаалах байр, Хүүхдийн тусламжийн 108 утасны төв, Дэлхийн зөн монгол ОУБ, НҮБ-ын Хүүхдийн сан болон нийслэл, 9 дүүрэг дэх Хүүхдийн эрхийн улсын байцаагчид зэрэг байгууллагын төлөөлөл оролцож, тэдгээрийн саналыг журмын төсөлд тусгасан болно. Энэхүү журмын төсөлд 15 байгууллагаас санал авах албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тэдгээрийн 10 байгууллагаас 35 санал ирүүлснээс 33, 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр гаргасан 2 саналын 1 саналыг журмын төсөлд тус тус тусгасан.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД



Ц.БААТАРХҮҮ

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

/"Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ыг батлах тухай/

№	Аргачлал	Асуудал	Дэлгэрэнгүй тайлбар /судалгаа байгаа бол хавсаргах/
1		Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх	Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25.11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, мөрдүүлэх эрх олгогдсон.
2	акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	Тухайн хэрэгжүүлснээр зорилгод хүрч чадах эсэхийг тогтоох шийдвэрийг тавьсан	Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.1-д эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэр бүлийн орчинд, боловсролын сургалтын байгууллага сургуулийн болон дотуур байрны орчинд, хуулийн этгээд хуульд заасан эрх эдэлж, үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалахаар заасан. Мөн зүйлийн 25.4 хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглосон бөгөөд 25.5-д хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй байхаар тус тус хуульчилсан. Иймд "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-аар цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хортой болон хориотой агуулгыг түгээснээс үүсэх эрсдэлийг таних, мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулахаар тусгалаа. Мөн уг үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгосноос гадна иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нийтэд ил тод мэдээлэхтэй холбогдсон харилцааг нарийвчлан тодорхой зохицуулснаар хуульд нийцүүлэн цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчсөн тохиолдолд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой болно.
3		Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	Журмын зорилго нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад оролцогч талуудын хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан зохицуулахаар заасан.

4	Актаар зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заах	Энэхүү журмаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан. Уг журмыг цахим орчинд хүүхдийг хамгаалах үүрэг бүхий талууд мөрдөнө.
5	тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актыг эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ." гэж заасныг үндэслэн энэхүү "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам" хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.
6	Бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заах	Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д "Захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болсонд тооцсон тохиолдолд уг шийдвэрийг мөн хуулийн 65 дугаар зүйлд заасан журмын дагуу хянан улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийж, "Захиргааны хэм хэмжээний актыг эмхэтгэлд нийтэлнэ." гэж заасны дагуу хүчингүй болгох акт байхгүй болно.
7	акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох	Журмын төсөл нь 4 зүйл, 23 хэсэг, 26 заалттай.
8	хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж	Энэхүү журмын талаар олон нийтээс 2024 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай санал авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудсанд байршуулсан. Мөн Журмын төсөлд санал авах уулзалтыг хууль тогтоомжоор хүүхэд хамгааллын чиглэлээр үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан 2024 оны 08 дугаар сарын 26, 09 дүгээр сарын 06, 11-ний өдрүүдэд 3 удаа зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт ГБХННХЯ, ХЗДХЯ, ЦХИХХЯ, БЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ, ХГБХХЕГ, ХХЗХ, ХХХУ-ний түр хамгаалах байр, Хүүхдийн сан болон нийслэл, 9 дүүрэг дэх Хүүхдийн эрхийн улсын НҮБ-ын Хүүхдийн сан болон нийслэл, 9 дүүрэг дэх Хүүхдийн эрхийн улсын байцаагчид зэрэг байгууллагын төлөөлөл оролцож, тэдгээрийн саналыг журмын төсөлд тусгасан болно. Энэхүү журмын төсөлд 15 байгууллагаас санал авах албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тэдгээрийн 10 байгууллагаас 35 санал ирүүлснээс 33, 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр гаргасан 2 саналын 1 саналыг журмын төсөлд тус тус тусгасан.
9	Зохихуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй

10	болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм
11		Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж хуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй
12		Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй
13		Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх	Үгүй
14		Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх	Үгүй
15		Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх	Үгүй
16		Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
17		Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй
18		Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
19	тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт гаргах эсэх	Эрх зүйн зохицуулалтын давхардал үүссэн эсэх	Үгүй
20		Шинээр төрийн байгууллага байгуулах эсэх	Үгүй
21	актыг шаардлагатай хүний нөөц,	Төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх эсэх	Үгүй

22	техник, эдийн засгийн тооцоог хийх	Захираганы шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй
23		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, эсхүл зардал бууруулах эсэх	Үгүй

2025.01.15

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД НАР ХАМТРАН БАТЛАХ "ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙГ ХОРИОТОЙ БОЛОН ХҮҮХДЭД ХОРТОЙ АГУУЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ ЖУРАМ"-ЫН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЕГ

№	САНАЛ ИРҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГЫН НЭР	ИРҮҮЛСЭН САНАЛ	САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ
1	БОЛОВСРОЛЫН ЯАМ 2024.11.11 1/2075	1. Журмын төслийн 2.2 дахь заалтыг мөн журмын 2.1.1, 2.2.3-д давхардуулан тусгасан тул "...шалгуур үзүүлэлт нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.16, 25.4 -д заасан дараах хүрээг хамарна," гэснийг "...заасан шалгуур үзүүлэлт нь дараах хүрээг хамарна," гэж өөрчлөх; 2. Журмын төслийн 2.5.1." цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг улирал бүр зохион байгуулах," гэснийг "цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтын талаар сургууль хөгжүүлэх дунд, богино хугацааны төлөвлөгөөндөө тусгаж үе шаттай зохион байгуулах," гэж өөрчлөх; 3. Журмын төслийн 2.5.2-д "сургуулийн болон дотуур байрны орчинд ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй хийх гэрээнд тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;" гэснийг "сургуулийн орчинд ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байх, нийгмийн сүлжээ (Facebook, Twitter, Instagram, Tiktok, Roblox, www.blizzard.com, гэх мэт)-ний платформд хандах эрхийн тохируулга хийдэг байхаар интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй хийх гэрээнд тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;" гэж өөрчлөх; 4. Журмын 2.5.4."сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих дотоод журмыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах." гэснийг "боловсролын сургалтын байгууллагын хэмжээнд мөрдөх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой дүрэм, журамд сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих зохицуулалтыг тусгах" гэж өөрчлөх.	Саналыг тусгав. Журмын төслийн 2.1 болон 2.2 дахь хэсгийн давхардлыг арилгаж өөрчлөн найруулав. Саналыг тусгав. 2.5.1. цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтын талаар сургууль хөгжүүлэх дунд, богино хугацааны төлөвлөгөөндөө тусгаж үе шаттай зохион байгуулах; Аливаа платформд хандах эрхийн тохиргоог хийх асуудал нь тухайн хүний ашиглаж буй төхөөрөмж /гар утас, таблет зэрэг/-д хийх тохируулга тул журмын төсөлд платформд хандах эрхийн тохируулгыг гэрээнд тусган хэрэгжүүлэхээр тусгах боломжгүй болно. Саналыг тусгав. 2.5.4. боловсролын сургалтын байгууллагын хэмжээнд мөрдөх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой дүрэм, журамд сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, мөрдүүлэх;
2	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,	Дэмжсэн.	

	НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ 2024.09.26 01/693		
3	ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО	1. Журмын төслийн 2.2.3-т заасан агуулгатай давхцал үүсгэх тул журмын төслийн 2.2.2 дахь заалтыг хасах.	Саналыг тусгав. Журмын төслийн заалтын давхардлыг арилгаж найруулав.
		2. Журмын төслийн 3.2 дахь хэсгийг "Хүн, хуулийн этгээд цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулга түгээсэн, эсхүл цахим орчин ашиглан хүүхдийг дарамталсан, урхидсан, дээрэлхсэн байж болзошгүй тохиолдолд хүүхдийн тусламжийн 108 дугаар, эсхүл хүүхдийн эрхийн улсын байцаагч, эсхүл цагдаагийн байгууллага, эсхүл зөвлөлд бичгээр болон цахим аль боломжит хэлбэрээр мэдэгдэнэ." гэж найруулах.	Саналыг тусгав. 3.2.Хүн, хуулийн этгээд цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулга түгээсэн, эсхүл цахим орчин ашиглан хүүхдийг дарамталсан, урхидсан, дээрэлхсэн байж болзошгүй нөхцөл байдлыг Зөвлөл, хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн 108 дугаарт мэдээлнэ.
		3. 3.4 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах - Эрх бүхий байгууллага нь хориотой болон хүүхдэд хортой агуулга түгээсэн эсэхийг тогтоож, холбогдох технологийн арга хэмжээг авах тухай шийдвэр, дүгнэлтийг Зохицуулах хороонд албан бичгээр хүргүүлнэ. - Эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлт бүхий албан бичигт дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:	Саналыг тусгав. Журмын төслийн 3.3-3.9 дэх хэсгийг өөрчлөн найруулав.
		4. Журмын төслийн 3.6 дахь хэсгийг "Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй" гэснийг "өөрийн цахим сүлжээнд мэдээлсэн" гэж өөрчлөх.	Саналыг тусгав. 3.6.Хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага нь нь энэ журмын 3.5-д заасан мэдэгдлийг тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл өөрийн цахим сүлжээнд мэдээлсэн цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.
		5. Журмын төслийн 3.8 дахь хэсэгт дараах агуулга бүхий хэсэг нэмэх Энэхүү журмын 3.7-д заасан цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 3.4-т заасан шийдвэр, дүгнэлтийг Эс хүлээн зөвшөөрвөл шийдвэр, дүгнэлт гаргасан байгууллагад гомдлоо, холбогдох тайлбар мэдээллийн хамт гаргах бөгөөд хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.	Саналыг тусгав. 3.8 дахь хэсгийг шинээр нэмж тусгав.
		6. 4.2 дахь хэсгээс "Энэ журмын 4.1-т заасан" гэснийг хасах.	Саналыг тусгав.

4	МОНГОЛЫН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАГЧДЫН ХОЛБОО 2024.11.12 01/008	1. "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ыг судлан үзэхэд, цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж, уг үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой зааж өгсөн байна гэж бидний зүгээс үзэж байгаа тул энэхүү журмыг бүхэлд нь Монголын Олон Суваг дамжуулагчдын Холбооны зүгээс дэмжиж байгаа болно.	-
5	МОНГОЛЫН ТЕЛЕВИЗУУДИЙН ХОЛБОО		
6	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ 2024.11.14 01/161	Тусгайлан өгөх саналгүй.	-
7	МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧДИЙН НЭГДСЭН ЭВЛЭЛ 2024.11.08 24.01/203	Тусгайлан өгөх саналгүй.	-
8	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД 2024.11.22 01/1951	1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 11 дэх хэсэгт заасан заалт нь уг журмыг батлах эрх олгосон заалт тул журмын төслийн 1.1 дэх заалтад тусгасан журмын зорилгыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15. 4.1.16-д хүүхдэд хортой болон хориотой агуулгыг тодорхойлсон заалтын хүрээнд цахим орчинд хүүхдийг хортой болон хориотой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах агуулгаар өөрчлөн тусгах; 2. Журмын төслийн 2.2-т заасан шалгуур үзүүлэлт нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.13-т заасны дагуу "Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын төсөлд тусгасан байх тул давхардуулсан зохицуулалт хийхгүй байхад анхаарах:	Саналыг тусгав. 1.1 дэх хэсгийг агуулгын хувьд найруулж тусгав. Саналыг тусгав. Журмын төслийн 2.2 дахь хэсэгт "Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын төсөлд тусгасан хүүхдэд

		хортой агуулга болон хориотой агуулгыг ялган томъёоллоо.
	3.Журмын төслийн 2.3-т "агуулгыг нийтлэхгүй" гэснийг "агуулгыг нийтлэхийг хориглоно." гэж өөрчлөн найруулж, холбогдох бүлэгт тусгах;	Саналыг тусгав. Захиргааны ерөнхий хуулийн 60.1.6-д заасан нийцүүлэн найруулав.
	4.Журмын төслийн 2 дугаар зүйлийн гарчгийг Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэж тодорхойлсон байх тул журмын төслийн 2.4 дэх заалтыг "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас хамгаалж, урьдчилан сэргийлэхэд эцэг, эх, асран хамгаалагч дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ." гэж өөрчлөх;	Саналыг тусгав. Томъёоллыг өөрчлөн найруулж тусгав.
	5.Журмын төслийн 2.5.1-д "цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг улирал бүр зохион байгуулах" гэснийг "цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан цахим болон танхимын сургалтыг зохион байгуулах" гэж өөрчлөн найруулав.	Саналыг тусгав. Уг заалтыг өөрчлөн найруулав.
	6.Журмын төслийн 3.1 дэх заалтын найруулгыг дахин хянах;	Саналыг тусгав. Томъёоллыг өөрчлөн найруулав.
	7."Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын төсөлд тус яамнаас "зөвлөлийн гаргах дүгнэлтэд тавигдах шаардлага, хэлбэрийг энэхүү журмаар тодорхой байдлаар дэлгэрэнгүй тусгах" талаар санал хүргүүлсэн. Иймд журмын төслийн 3.4-т дурдсан хүүхдэд хориотой агуулгыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хянан үзэж, хориотой агуулга бүхий тохиолдолд авах арга хэмжээ, дүгнэлт гаргах үйл ажиллагааг Зөвлөлийн ажиллах журамд эсхүл энэхүү журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг давхардуулахгүйгээр тодорхой тусгах нь зүйтэй;	Саналыг тусгав. Энэхүү журамд зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлт бүхий албан бичигт зайлшгүй тусгах мэдээллийн талаар нарийвчлан тусгаж, Орон тооны бус зөвлөлийн ажиллах журамд шаардлагатай өөрчлөлтийг тусгав.
	8. Журмын төслийн 3.8-д "үйлчилгээ эрхлэгчид" гэсний дараа "хүргүүлж, дараах арга хэмжээг авна." гэж өөрчлөн найруулав;	Саналыг тусгав. Журмын төслийн 3.3-3.9 дэх хэсгийг өөрчлөн найруулав.
	9.Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээний хэрэгжилтийг тухай бүр Зөвлөлд эргэн тайлагнах агуулга бүхий зохицуулалтыг журмын төсөлд нэмж тусгах;	Саналыг тусгав. Журмын төслийн 4.1 дэх хэсэгт санал тусгав.

	10. Журмын төслийн 3 дугаар зүйлд цахим орчинд хүүхдийг хортой болох хориотой агуулгаас хамгаалах асуудлаар цахим орчинд үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох арга хэмжээ тусгаснаас өөрөөр Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан төрийн байгууллага, албан тушаалтан, хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч, эцэг, эх асран хамгаалагчдын үүргийг тусгаагүй байгааг анхаарах 11. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.2-т заасны дагуу хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, цахим сүлжээний талаарх агуулгыг тусгаагүй орхигдуулсан байгааг анхаарах; 12. Журмын төслийн 4 дүгээр зүйлд энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгах; 13. Журмын төслийн бичвэрийн утга, найруулгыг дахин нягталж, Орон тооны бус зөвлөлийн ажиллах журамтай уялдуулах шаардлагатай. 14. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх. хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэсэн заалтын дагуу хамтарсан тушаалын төсөлд санал авахаар ирүүлэх	Саналыг тусгав. Журмын төсөлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас хамгаалах асуудлыг тусгасан бөгөөд энэхүү журмын төслийн 3 дугаар зүйлд аливаа хүн хуулийн этгээд хориотой болон хүүхдэд хортой агуулгыг илрүүлэн мэдээлэх үүрэг хүлээхээр тусгав. Саналыг тусгав. Журмын төслийн 2.1 дэх хэсэгт хүүхдийн хориотой агуулгыг тодорхойлж тусгасан бөгөөд Орон тооны бус зөвлөлөөс тодорхойлох хүүхдэд хортой агуулгын шалгуурын талаар тусгав. Саналыг тусгав. Журмын төслийн 4.3 дахь хэсгийг нэмж тусгав. Саналыг тусгав. Журмын төслийн найруулгад редакцын засвар оруулав. Саналыг тусгав. Хамтарсан тушаалын төслийг боловсруулж хүргүүлэв.
9	1. Журмын "Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" хэсэгт дараах заалтыг нэмэх: Тамхины хяналтын суурь конвенц, Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх, утаат болон электрон тамхи, шинэ төрлийн тамхины бүтээгдэхүүнийг (өсвөр үеийнхний шүтэн биширч, даган дуурайдаг хүмүүсээр хэрэглүүлэх маягаар) далд хэлбэрээр сурталчлах, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэх аргачлал заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан, бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг харуулахыг хориглох;	Саналыг тусгав. Журмын төслийн 2.2.8-д нэмж тусгав.

		Бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, дэлгэцээр, кино, жүжиг, реклам, зар сурталчилгааны архи, тамхитай холбоотой дүрсийг бүдгэрүүлж харагдахгүй байлгах, нуусан дүрсний дор “Тамхи Таны эрүүл мэндэд хортой.” гэсэн бичвэр бичихийг хориглох.”	Саналыг тусгав. Тамхи болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж буй агуулгыг харуулахгүй байхаар тусгасан.
		Журмын 2.5 “Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд боловсролын сургалтын байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэдэгт нэмэлтээр доорх заалтыг нэмэх: 2.1. Сургуулийн дотоод орчинд сүлжээ унагаагч байршуулах 2.2. Багш, ажилчид өөрсдөө үлгэрлэх, өөрийн хувийн цахим хуудаснаа далд хэлбэрээр хориотой болон хортой агуулгатай далд мэдээлэл, сурталчилгааг түгээхгүй байх;	Радио долгионы тухай хуулийн 8.3-т Сүлжээ унагаагч буюу сүлжээ сарниулах төхөөрөмжийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашиглахыг хориглосон тул уг асуудлыг журмаар зохицуулах боломжгүй.
		Журмын төслийн “4.1.Энэхүү журмын хүрээнд гомдол, мэдээлэл хүлээн авсан, түүний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгууллага нь хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Зөвлөлд хүргүүлж, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ. 4.2.Зөвлөл нэгдсэн тайланг бэлтгэн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулна.” гэж заасан нь орон тооны бус зөвлөлийн хуулиар хүлээсэн бус зохицуулалт байх тул 4.1, 4.2 дахь заалтыг хасаж, журмын хэрэгжилтэд хяналт тавих тодорхой болгож үүрэгжүүлэх шаардлагатай.	Саналыг тусгав. Журмын төслийн 4.2 дахь хэсгийг хасаж, 4.1 дэх хэсгийг найруулав.
		Журмын төслийн 1.2-т заасан “журмыг холбогдох зохицуулалтыг” гэснийг “холбогдох журмын зохицуулалт” гэж өөрчлөх	Саналыг тусгав.
		Төслийн 2.5.2, 2.6-д заасан “интернэтийн үйлчилгээ эрхлэгч” гэснийг нэр томъёогоор бичих	Саналыг тусгав. Журмын төсөлд нэр томъёог тайлбар байдлаар тусгав.

		Төслийн 2.5.2-т заасан “интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй хийх гэрээнд” гэснийг “интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах гэрээнд” гэж өөрчлөх Төслийн 3.9-д заасан “технологийн боломжит хүрээнд” гэснээс “технологийн” гэснийг хасах Дэмжсэн	Саналыг тусгав. 2.5.2 дахь заалтыг өөрчлөн найруулав. Саналыг тусгав.
11	МОНГОЛЫН АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗУУДИЙН ХОЛБОО 2024.11.14 02/79		-
12	2025.01.16-ний өдрийн хэлэлцүүлгийн оролцогч	2.2.3 дахь хэсгийг харахаар зөвхөн 16 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг хамаарахаар ойлгогдоод байна. Гэтэл Эрүүгийн хуульд заасан бүх төрлийн гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдэж болно. Тэгэхээр бүлэг зааж оруулах хэрэг байна уу? Хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт хортой нөлөө үзүүлэхүйц гэмт хэргийн үйлдэл, аргыг нарийвчлан харуулсан гэсэн байдлаар оруулбал ямар вэ? Ерөнхий утгаараа. 2.6-д хуулийн 25.6-д заасан арга хэмжээг авах гэж заасан байна. Энэ журамд олон хууль байгаа. Хүүхэд хамгааллын тухай хууль гэж тодорхой оруулж өгөх.	Саналыг тусгав. 2.2.3 дахь заалтыг найруулав. Журмын төслийн 1.1-д заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийг цаашид хууль гэж ерөнхий заахаар тусгасан байх тул хэвээр үлдээлээ.